

ТАЙЛБАР БИЧИГ

Дархан-Уул аймаг, Дархан сум, "7-р цэцэрлэг" -ийн барилгын блок-1, 2, 3, 4 -н агаар сэлгэлтийн системийн засварын ажлын зургийг хийж гүйцэтгэхдээ ажлын тоо хэмжээний нэр төрөл, газар дээр нь хийсэн хэмжилт, судалгааг үндэслэн зураг төслийн "ВАСТ САЙЗ КОНСТРАКШН" ХХК-д боловсруулав.

Халаалт, агаар сэлгэлтийн хэсгийн ажлын зургийг хийж гүйцэтгэхдээ:

- БНБД 23-01-09 Барилгад хэрэглэгдэх уур амьсгал, геофизикийн үзүүлэлт,
- БНБД 23-02-09 Барилгын дулаан хамгаалалт,
- БНБД 23-103-10 Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт,
- БНБД 41-01-11 Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер,
- БНБД 31.03-03 Олон нийт иргэний барилгыг мөрдлөгө болгов.

Барилга баригдах газрын цаг уурын нөхцөл:

- Гадна агаарын хэм хүйтний улиралд -34.1 °С
- Галалгааны үеийн дундаж температур -7.9 °С
- Галалгааны үеийн үргэлжлэх хугацаа 226 хоног

АГААР СЭЛГЭЛТ:

Агаар сэлгэлтийн системд блок-1, 2, 3, 4 -д ариун цэврийн өрөө болон гал тогоо бусад ангийн өрөөнүүдэд ЕС-1-4 ердийн системийн агаар цуглуулах хэвтээ хоолойг шинээр хийж (хуучин хоолойг буулгах) босоо шахтуудыг сэтгэж цэвэрлэн адрын хөндийд шинээр хэвтээ цуглуулах дулаалгатай хоолойгоор нэгтгэн шувуун нуруун дээврээс дээш гарган дефлектор хийхээр төлөвлөв.

Өрөө тасалгаануудад одоо байгаа сараалжыг буулгаж босоо суваг шахтыг сэтгэж цэвэрлэн хэвтээ сорох хоолой, сараалжыг шинээр хийхээр төлөвлөв. Мөн адрын хөндийд цуглуулах хэвтээ хоолой болон нэгтгэх босоо хоолойг шинээр хийж сайтар дулаалан дээврээс дээш гарган дефлектор хийж өгнө.

Дээврээс дээш гаргаж буй хоолойн зай завсарыг битүүлж, ус тусгаарлах арга хэмжээ авна. Ариун цэврийн өрөөнөөс агаар сорох сараалжинд бага чадлын сорох сэнсийг унтраалгын хамт суурилуулж өгнө. Хуучин одоо байгаа хэвтээ сорох хоолой, модон таазыг буулгана. Агаар сорох хоолойг шинээр хийж дууссаны дараа гипсэн таазыг цэвэр үзэмжтэй хийж хоолойг бүрэн далдална. Мөн сараалж шугам хоолой нэвтлэн гарсан хана таазыг битүүлж засварлана.

Агаар сэлгэлтийн системийг угсрах, угаах, турших ажлыг гүйцэтгэхдээ БНБД 40-06-15-ыг баримтлан гүйцэтгэвэл зохино. Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ техник аюулгүй ажиллагааны норм дүрмийг баримтлан ажиллах хэрэгтэй.

ТАНИХ ТЭМДЭГ

Нэр	Тэмдэглэгээ	
	Байгуулалт	Тойм
- Салхивчийн суваг		
- Агаар сорох тор		
- Салхивчийн хоолой		
- Агаар сорох ердийн систем		
- Агаар сорох механик систем		
- Агаар оруулах механик систем		
- Дээврийн сэнс		

ХАЛААЛТЫН ЗУРГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Барилга байгууламжийн нэр	Барилгын эзэлхүүн м³	Гадна агаарын тооцоот температур °С	Дулааны ачаалал Вт (ккал/цаг)				Хүйтэн зарцуулалт	Цахилгаан хөдөлгүүрийн хүчин чадал, кВт
			Халаалт	Салхивч	Хэр.хал ус	Бүгд		
Цэцэрлэгийн барилга	5529	-34.1 °С	- (-)	- (-)	- (-)	- (-)	-	-
Нийт								

ДАВТАН ХЭРЭГЛЭГДЭХ ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Д/д	ГОСТ, Марк	Зургийн нэр	Тайлбар
1	3.904-10	Агаар дамжуулах хоолойг бэхлэх	-
2	1.494-10	Салхивчийн тор	-

	Дархан-Уул аймаг, Дархан сум, 7-р цэцэрлэгийн барилгын агаар сэлгэлтийн системийн засвар			ХАС		
	Захирал	Н.Эрдэнэбаяр		Таних тэмдэг, тайлбар бичиг, үндсэн үзүүлэлт		
	Инженер	О.Батцоож		Масштаб:		
Гүйцэтгэсэн	О.Батцоож		Үе шат	Хуудас	Бүх хууд	
			А3	2	17	